



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 07 дугаар сарын 31
№28 (1276)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠯ ᠠᠯᠪᠠᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

363. “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай	2077
364. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2078
365. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2079
366. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2081
367. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2082
368. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2086

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

369. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай	Дугаар 56	2088
370. Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 57	2089
371. Хянан шалгах түр хороо байгуулах тухай	Дугаар 60	2090
372. Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай	Дугаар 62	2094
373. Хянан шалгах түр хороо байгуулах тухай	Дугаар 63	2095
374. Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай	Дугаар 64	2098

375.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 65	2102
376.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 66	2106
377.Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 67	2107
378. 1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 68	2110
379.Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай	Дугаар 69	2114
380.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 70	2116
381.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 77	2118

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

382.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тайлбарлах тухай	Дугаар 24	2120
---	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

383.Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол		2136
--	--	------



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
ХОТ

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.5.14 дэх заалт нэмсүгэй:

“22.5.14.цахилгаан эрчим хүчний 5 мегаваттаас дээш, эсхүл дулааны эрчим хүчний 1.5 мегаваттаас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн үндсэн болон туслах тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг 90 хувь хөнгөлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2029 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Индрига Фоде на Ной

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠯ

ᠠᠵᠤ ᠠᠬᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠡᠭᠭᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ
ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠠᠲᠦ᠋ᠷᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠯ
ᠨᠡᠮᠡᠯᠲᠤ ᠣᠷᠤᠭᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ

ᠠᠵᠤ ᠠᠬᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠡᠭᠭᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠠᠲᠦ᠋ᠷᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠯᠢᠨ 22 ᠳᠤᠭᠠᠭᠠᠷ ᠵᠢᠯᠳᠤ ᠳᠣᠷᠤ ᠳᠤᠷᠳᠠᠨ ᠠᠭᠤᠯᠤᠭᠠᠲᠤ 22.5.14 ᠳᠡᠬᠤ ᠵᠠᠭᠠᠯᠲᠤ
ᠨᠡᠮᠤᠰᠦᠭᠡᠢ:

“22.5.14.цахилгаан эрчим хүчний 5 мегаваттаас дээш,
эсхүл дулааны эрчим хүчний 1.5 мегаваттаас дээш хүчин чадалтай
эх үүсвэрийн үндсэн болон туслах тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл
ажиллагааны орлогод ногдох албан татварыг 90 хувь хөнгөлнө.”

ᠠᠵᠤ ᠠᠬᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠡᠭᠭᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠣᠷᠯᠣᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠠᠲᠦ᠋ᠷᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠯᠢᠨ 22 ᠳᠤᠭᠠᠭᠠᠷ ᠵᠢᠯᠳᠤ ᠳᠣᠷᠤ ᠳᠤᠷᠳᠠᠨ ᠠᠭᠤᠯᠤᠭᠠᠲᠤ 22.5.14 ᠳᠡᠬᠤ ᠵᠠᠭᠠᠯᠲᠤ
ᠨᠡᠮᠤᠰᠦᠭᠡᠢ:

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠯ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/38 дугаар зүйлийн 38.1.21 дэх заалт:

“38.1.21. Засгийн газраас энэ хуулийн 40.5-д заасны дагуу тогтоосон төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмж.”

2/40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэг:

“40.5. Цахилгаан эрчим хүчний 5 мегаваттаас дээш, эсхүл дулааны эрчим хүчний 1.5 мегаваттаас дээш хүчин чадалтай эх үүсвэр барих, суурилагдсан хүчин чадлыг өргөтгөх, тухайн шинэ эх үүсвэрийг цахилгаан дулаан хангамжийн системд холбох шугам болон дагалдах дэд бүтцийн ажлын үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.”

2 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсгийн дугаарыг “40.6” гэж, мөн хэсгийн “40.4-т” гэснийг “40.4, 40.5-д” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2029 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/20¹ дүгээр зүйл:

“20¹ дүгээр зүйл. Улс төрд нөлөө бүхий зарим этгээдэд тавих хориглолт, хязгаарлалт

20^{1.1}. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл түүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд төрөөс санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, арилжааны шинжтэй төсөл, хөтөлбөр, төрөөс олгох хөнгөлөлт, баталгаа, хандив, зээл хүртэгч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч байж болохгүй.

20^{1.2}. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг даргын эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд төрийн албаны удирдах албан тушаал эрхлэх, төрийн болон орон нутгийн өмчит компани, улсын үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглоно.

20^{1.3}. Энэ хуулийн 20.2, 20^{1.1}, 20^{1.2}-т заасныг зөрчсөн нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон бол тухайн албан тушаалтныг чөлөөлөх, огцруулах, эгүүлэн татах үндэслэл болно.

Тайлбар: -Энэ хуулийн 20^{1.1}, 20^{1.2}-т заасан “хүүхэд” гэдэгт эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн одоо хамт амьдарч байгаа төрсөн, үрчлэн авсан хүүхдийг ойлгоно.

-Энэ хуулийн 20.2, 20¹.1-д заасан “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав, түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.

-Энэ хуулийн 20¹.2-т заасан “төрийн албаны удирдах албан тушаал” гэдэгт Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасан томилогдох төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтан, мөн хуулийн 18.2-т заасан тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалыг ойлгоно.”

2/29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэг:

“29.6.Энэ хуулийн 20.2, 20¹.1, 20¹.2-т заасныг зөрчсөний улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж Авлигатай тэмцэх газар үзвэл энэ талаарх мэдээллийг прокурорт хүргүүлнэ.”

2 дугаар зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “тайлагнадаг” гэсний дараа “, танилцуулдаг” гэж, “аймаг, нийслэлийн Засаг дарга” гэсний өмнө “тэдгээрийн тэргүүн дэд, дэд дарга, орлогч дарга,” гэж, “Засгийн газрын агентлагийн дарга,” гэсний дараа “Улсын Их Хуралд суудал бүхий намын дарга,” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “шүүгч” гэсний дараа “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасныг баримтлан” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч,” гэснийг “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны нийлүүлэгч, гүйцэтгэгч,” гэж, мөн хэсгийн “хувь,” гэснийг “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч,” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалтын “20.2-т” гэснийг “20.2, 20¹.1-д” гэж, “нэгээс тав” гэснийг “хорь” гэж, “торгох,” гэснийг “торгож,” гэж, мөн зүйлийн 29.2.2 дахь заалтын “21.4-т” гэснийг “21.4, 23.5-д” гэж, мөн зүйлийн 29.2.3 дахь заалтын “20.4-т” гэснийг “20.4, 20¹.2-т” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан энэ хуулийн 20¹.1-д хамаарах гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэвээр байна.

2 дугаар зүйл. 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө уг хуулийн 20¹.2-т заасан Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг даргын эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд төрийн албаны удирдах албан тушаал, төрийн болон орон нутгийн өмчит компани, улсын үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагад ажиллаж байгаа бол тухайн этгээд 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор холбогдох эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж, ажлаас чөлөөлөгдөх арга хэмжээ авна.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

᠑᠙᠘᠘ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл

Модуль Фолло да Нөхцөл

᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр

᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл
᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл
᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл

᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл
᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл
᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл

᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл
᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл
᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл

᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл
᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр /᠑᠙᠙᠗ он ᠑᠗ сар ᠑᠒-ны өдөр хүртэл



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар
хот

Хянан шалгах түр хороо байгуулах тухай

Монгол Улсын эмийн үнэ, хүртээмж, худалдан авах боломж, үнэ бүрдлийн судалгаа, эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг шалгах шаардлагыг харгалзан Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах”-аар тогтоосугай.

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай:

1/зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг батлах шийдвэр, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал;

2/зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт дахь эмийн чанар, аюулгүй байдал, чанарын баталгаажуулалтын нөхцөл байдал;

3/зах зээлд худалдаалагдаж байгаа зайлшгүй шаардлагатай эмийн үнийн өсөлтийн бодит шалтгаан, нөхцөл;

4/зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт дахь эмийн хүртээмж, тулгамдаж байгаа асуудал;

5/Монгол Улсад эмийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох саналыг танилцуулах.

3.Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Олонхыг төлөөлөн:

Д.Батлут	Улсын Их Хурлын гишүүн
Б.Жаргалмаа	Улсын Их Хурлын гишүүн
М.Оюунчимэг	Улсын Их Хурлын гишүүн
Ц.Сандаг-Очир	Улсын Их Хурлын гишүүн
Ж.Чинбүрэн	Улсын Их Хурлын гишүүн

Цөөнхийг төлөөлөн:

Б.Бейсен	Улсын Их Хурлын гишүүн
Ц.Туваан	Улсын Их Хурлын гишүүн

4.Улсын Их Хурлаас хугацааг сунгаснаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо нь энэ тогтоол баталсан өдрөөс хойш зургаан сарын дотор тусгай шалгалт явуулж тайланг санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулсугай.

5.Энэ тогтоолыг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

1. /рестинг гэрээг 2018 он 12 сарын 15-нд үргэлжлүүлж, үргэлжлүүлсэн гэрээний хугацааг 2023 он 12 сарын 31-н хүртэл өргөснийг үндэслэн үргэлжлүүлсэн гэрээний үйлчилгээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл

2. Гэрээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл

3. Гэрээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл:

- а. 2023 оны 1-р сарын 1-н хүртэл үйлчилгээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл
- б. 2023 оны 2-р сарын 1-н хүртэл үйлчилгээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл
- в. 2023 оны 3-р сарын 1-н хүртэл үйлчилгээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл
- г. 2023 оны 4-р сарын 1-н хүртэл үйлчилгээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл
- д. 2023 оны 5-р сарын 1-н хүртэл үйлчилгээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл

4. Гэрээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл:

- а. 2023 оны 6-р сарын 1-н хүртэл үйлчилгээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл
- б. 2023 оны 7-р сарын 1-н хүртэл үйлчилгээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл

5. Гэрээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл
6. Гэрээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл

7. Гэрээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл

8. Гэрээний үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргах үндэслэл



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 10,235,124.6 сая /арван их наяд хоёр зуун гучин таван тэрбум нэг зуун хорин дөрвөн сая зургаан зуун мянга/ төгрөгөөр баталсугай.

2.Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 11,359,914.0 сая /арван нэгэн их наяд гурван зуун тавин есөн тэрбум есөн зуун арван дөрвөн сая/ төгрөгөөр баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠭᠠᠨ

Mongol Gol - da Ykh Hural da Doolgo



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар
хот

Хянан шалгах түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэй, 6 сарын хугацаатайгаар байгуулсугай:

Олонхыг төлөөлөн:

Э.Бат-Амгалан	-Улсын Их Хурлын гишүүн
Г.Ганболд	-Улсын Их Хурлын гишүүн
Б.Жаргалмаа	-Улсын Их Хурлын гишүүн
Х.Нямбаатар	-Улсын Их Хурлын гишүүн
М.Оюунчимэг	-Улсын Их Хурлын гишүүн
Ж.Сүхбаатар	-Улсын Их Хурлын гишүүн
Б.Энхбаяр	-Улсын Их Хурлын гишүүн

Цөөнхийг төлөөлөн:

С.Ганбаатар	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганбат	-Улсын Их Хурлын гишүүн
Т.Доржханд	-Улсын Их Хурлын гишүүн
О.Цогтгэрэл	-Улсын Их Хурлын гишүүн

2.Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани, орон нутгийн өмчийн оролцоотой “Тавантолгой” хувьцаат компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагааг иж бүрэн хянан шалгахгаар тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр улс орон даяар тэмдэглэхээр тогтоосугай.

2.Ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Анхдугаар Үндсэн хуулийн түүхэн ач холбогдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, эрдэм шинжилгээний турал зохион байгуулах, түүхэн судалгааны болон танин мэдэхүйн бүтээл туурвиж нийтийн хүртээл болгох, Үндсэн хуулиа эрхэмлэн дээдлэх үзэл санааг иргэдэд тайлбарлан таниулах, төрийн ёслол хүндэтгэлийн бусад арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулахыг Ажлын хэсэг /Л.Мөнхбаатар/-т даалгасугай.

4.Ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/-нд, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т даалгасугай.

6.Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Монгол Улсын Их Хурлын 2023 оны
64 дүгээр тогтоолын хавсралт

**БҮГД НАЙРАМДАХ УЛСЫГ ТУНХАГЛАЖ, АНХДУГААР ҮНДСЭН
ХУУЛЬ БАТАЛСНЫ 100 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Мөнхбаатар -Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга

Гишүүд:

Д.Тогтохсүрэн -Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга

О.Цогтгэрэл -Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга

Н.Энхболд -Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга

Д.Лүндээжанцан -Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх

Б.Энх-Амгалан -Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга /зөвшилцсөнөөр/

У.Бямбасүрэн -Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга /зөвшилцсөнөөр/

Г.Чулуунбаатар -Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч, Академич /зөвшилцсөнөөр/

Ц.Цэрэндорж -Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал /зөвшилцсөнөөр/

Э.Одмөнх -Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Төрийн ёслолын газрын дарга /зөвшилцсөнөөр/

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Ц.Батбаатар -Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга

---oOo---

Зөвшөөрөгчид өргөтгөлийн
хугацааг өргөснийг үндэслэн

хуульчилж өргөснийг
үндэслэн

.. Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

.. Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн
Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн
Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

.. Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн
Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн
Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

Мөрдөгчид өргөтгөлийн хугацааг өргөснийг үндэслэн өргөснийг үндэслэн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар
хот

Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 56 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Монгол Улсын Их Хурлын 2023 оны
65 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Тамгын дарга	2 980 000
2	Үндэсний аудитын газрын бүтцийн нэгжийн дарга, захирал, тэргүүлэх аудитор	2 780 000
3	Үндэсний аудитын газрын хэлтэс, албаны дарга, менежер	2 650 000
4	Үндэсний аудитын газрын ахлах аудитор, ахлах шинжээч	2 530 000
5	Үндэсний аудитын газрын аудитор, шинжээч	2 380 000
6	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын дарга	2 650 000
7	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга, аудитын менежер	2 530 000
8	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор, ахлах шинжээч	2 380 000
9	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын аудитор, шинжээч	2 130 000

---oOo---



Зөвхөн ажиллагаа
гэрээний үндсэн дээр

З.Н.З.

2023 оны 12 сарын 28-ны өдөр /2023 оны 12 сарын 28-ны өдөр/

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМАГ

2023 оны 12 сарын 28-ны өдөр /2023 оны 12 сарын 28-ны өдөр/

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМАГ

2023 оны 12 сарын 28-ны өдөр /2023 оны 12 сарын 28-ны өдөр/

2023 оны 12 сарын 28-ны өдөр /2023 оны 12 сарын 28-ны өдөр/

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМАГ
2023 оны 12 сарын 28-ны өдөр /2023 оны 12 сарын 28-ны өдөр/

2023 оны 12 сарын 28-ны өдөр /2023 оны 12 сарын 28-ны өдөр/

2023 оны 12 сарын 28-ны өдөр /2023 оны 12 сарын 28-ны өдөр/

2023 оны 12 сарын 28-ны өдөр /2023 оны 12 сарын 28-ны өдөр/

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар
хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.9 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 63 дугаар тогтоолын үндэслэл хэсгийн “Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг,” мөн тогтоолын 1 дэх заалтын “дэд дарга, Төрийн аудитын байгууллагын дарга,” гэснийг тус тус хассугай.

2.Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын Төрийн аудитын байгууллагын дарга

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ

ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ

ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ

ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ

ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ
ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ ᠲᠤᠭᠲᠤᠭᠠᠨ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

1/Монгол Улсын Засгийн газраас боловсруулан өргөн мэдүүлж байгаа тухайн жилийн төсвийн төсөл, гүйцэтгэлийн дүн, батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлтэй зөрж байгаад дүн шинжилгээ хийх, холбогдох хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хариуцлагажуулах зорилгоор хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа боловсруулан Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хяналтын сонсголыг төсвийн гүйцэтгэлийн хэлэлцүүлэгтэй уялдуулан зохион байгуулах шаардлагад нийцүүлэн Монгол Улсын тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, аудит хийх, өргөн мэдүүлэх, батлах хугацаанд өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулан Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/Монгол Улсын тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулгад төсвийн орлого, зарлагыг эдийн засгийн ангиллаар болон төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн баталсан төсвөөс зөрүүтэй зарцуулсан шалтгааныг тайлбарласан дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргаж байх;

4/Зээлийн үйлчилгээний төлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү их байгаад дүгнэлт хийж, цаашид төсвийг бодитой төлөвлөж ажиллах.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар
хот

1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж заасан Зорилт 1.2-т тусгагдсан үйл ажиллагааг яаралтай хэрэгжүүлэх шаардлагын үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хилийн боомт дахь ачаа тээврийн урсгалыг сайжруулах, нүүрсний экспорт, эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасгай:

1/1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах;

2/Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хэлэлцээр”-ийн хэрэгжилтийн хүрээнд бусад боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалт, хил холболтыг эрчимжүүлэх;

3/“Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг зураг төслийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх “Ганцмод” боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компаниар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас санхүүжүүлэх;



4/Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх “Ганцмод” боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компани болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд үе шаттайгаар жил бүр 20 сая тонноос доошгүй хэмжээний нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, зах зээлийн зарчимд нийцүүлэн урт хугацааны худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрөх;

5/энэ тогтоолын дагуу байгуулах аливаа гэрээг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөл /off-take/-өөр байгуулахгүй байх;

6/Тавантолгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, бусад уул уурхайн болон уул уурхайн бус бүтээгдэхүүн, бараа, түүхий эдийг тээвэрлэх боломжийг бүрдүүлэх;

7/энэ тогтоолын 1 дэх заалтын 3, 4 дэх дэд заалтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, хамтран ажиллах;

8/“Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор газар ашиглах асуудлыг шуурхай шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтийн талаар 2023 оны 10 дугаар сард багтаан Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар
хот

Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Улсын Их Хурлаас 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлээр зарим зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсонтой холбогдуулан салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг бүрэн хамруулах, холбох, нэвтрүүлэлт хийх, зөвшөөрлийн нэгдсэн сангийн цахим системийг үүсгэх, хөгжүүлэх, хяналт тавих, цахим системийн мэдээллийн чанар, уялдаа холбоог сайжруулах, мэдээллийг нийтэд нээлттэй ил тод байлгах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах ажлыг эрчимжүүлэх;

3/энэ тогтоолын 2 дахь дэд заалтад заасан арга хэмжээний талаарх тайланг Монгол Улсын Их Хуралд 2023 оны 10 дугаар сард багтаан танилцуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмааг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгаланг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Салдангийн Одонтуяаг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр баталсугай.

3.Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг, 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хууль тогтоомжийн төсөлд дүн шинжилгээ, хууль зүйн судалгаа хийх чадавхыг сайжруулах, парламентын судалгааны албыг өргөтгөн зохион байгуулах зорилгоор “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 44 дүгээр тогтоолын 3 дахь заалтад заасан арга хэмжээний хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн барилгыг Улсын Их Хурлын Тамгын газарт шилжүүлэх арга хэмжээг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой 2023 оны 07-12 дугаар сарын зардлыг өмнөх түвшинд тооцож Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны батлагдсан төсвийн багцаас гарган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар, холбогдох төсвийн захирагч нарт даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 34 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 05 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар
хот

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тайлбарлах тухай

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт *"Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 4/ Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах"* гэж, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэгт *"Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 25.8.4. шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх"* гэж тус тус заасны дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах нь зүйтэй гэж үзэв.

Хоёр. Тайлбар гаргах хэрэгцээ, шаардлага

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан *"... эргэлзээ гарвал түүнийг ... шүүгдэгчид ... ашигтайгаар шийдвэрлэх"* буюу *"in dubio pro reo"* зарчим нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шударга явагдах зорилгыг хангахын тулд гэм буруугүйд тооцох зарчимтай зэрэгцэн үйлчилдэг бөгөөд хуульт ёсны шууд тусгал болж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгдэгчийн эрхийн хамгаалалтыг илэрхийлнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарах шийдвэр бүхэн, түүний дотор шүүгдэгчийн гэм бурууг эцэслэн тогтоох ажиллагаа зөвхөн нотлох баримтад үндэслэсэн байх ёстой тул хэрэгт хамааралтай нотлох баримтуудыг бүгдийг нь шалгасан боловч тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхэд эргэлзээ гарсан бол шүүхээс түүнийг шүүгдэгчийн талд ашигтайгаар шийдвэрлэх буюу *"in dubio pro reo"* зарчмыг баримтална.

Энэхүү зарчим нь шүүгдэгчийн гэм буруу нь нотлох баримтаар хөдөлбөргүй тогтоогдоогүй бол таамаглалд үндэслэж түүнийг гэм буруутай гэж үзэж болохгүй гэх оюун дүгнэлтэд тулгуурладаг ба аливаа дур зорго, хэлмэгдүүлэхээс хүнийг хамгаалах шүүхийн үүргийг тодорхойлдог.

2.1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан уг зарчмыг шүүхээс зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах хэрэгцээ, шаардлага нь:

Нэгдүгээрт, шүүхийн шийдвэр, практикаар тогтоогдож байна. 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хооронд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “... **эргэлзээ гарвал түүнийг ... шүүгдэгчид ... ашигтайгаар шийдвэрлэх**” зарчмыг баримтлан шийдвэрлэсэн анхан, давах, хяналтын шатны шүүхийн нийт 58 шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд анхан болон давж заалдах шатны шүүхүүдээс энэхүү зарчмыг хэрэглэж шийдвэрлэсэн шийдвэрүүдийн 70 орчим хувь нь дээд шатны шүүхээс өөрчлөгдөж, хүчингүй болжээ.

Тодруулбал, нийт 58 шийдвэрийн 31 буюу 53.44% нь өмнөх шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон, 10 буюу 17.24% нь өөрчлөлт оруулсан, 17 буюу 29.31%-ийг хэвээр үлдээсэн байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “... **эргэлзээ гарвал түүнийг ... шүүгдэгчид ... ашигтайгаар шийдвэрлэх**” зарчмыг баримтлан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд хийсэн практик судалгаагаар шат шатны шүүхүүд тухайн зарчмын зорилго, агуулгын талаар нэгдмэл ойлголтод хүрээгүй, эсвэл агуулгыг хэт өргөжүүлэн тайлбарлах, ижил тохиолдлуудад өөрөөр, эсвэл хэрэглэх ёсгүй тохиолдолд хэрэглэх зэргээр дурдсан ач холбогдлыг алдагдуулахуйц нөхцөл байдлууд тогтоогджээ.

Хоёрдугаарт, энэхүү зарчим нь хуулийн хэм хэмжээнд хоёрдмол утгаар томъёологдсоноос шүүхүүд зөрүүтэй тайлбарлаж, дэлхий нийтээр түгээмэл хүлээн зөвшөөрсөн агуулгаас өөрөөр тайлбарлан хэрэглэж байх тул холбогдох хуулийн заалтыг уг зарчмын агуулга, зорилгод нийцүүлэн тайлбарлах шаардлагатай байна.

Гадаад улс орнуудын эрүүгийн процессын хуульд шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ гарвал түүнд ашигтайгаар шийдвэрлэх нь нийтлэг байдлаар тусгагдсан байдаг бол харин шүүхээс хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал ашигтайгаар шийдвэрлэх зохицуулалт нь түгээмэл байдаггүй.

Энэхүү зарчмын үүсэл хөгжил болон онолын мөн чанар талаас нь авч үзвэл шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг нотлох баримтаар тогтоогдсон хэргийн үйл баримтыг үнэлэхэд үүссэн эргэлзээг шийдвэрлэхэд голчлон хэрэглэгддэг.

Үүнээс үүдэн материаллаг болон процессын хуулийг тайлбарлах, хэрэглэхэд үүссэн эргэлзээ гэдэгт юуг, хэрхэн хамааруулж ойлгох талаар нарийвчлан тодорхойлж, тайлбарлах шаардлага бий болж байна.

2.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт **“Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч ... шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг ... шүүгдэгчид ... ашигтайгаар шийдвэрлэнэ”** гэж зааснаас үзэхэд эргэлзээг хоёр тохиолдолд хэрэглэхээр хуульчилжээ.

2.2.1. Хэргийн үйл баримт буюу нотолгоонд үүссэн эргэлзээний улмаас **“шүүгдэгчийн гэм буруутай эсэх”**-ийг тогтооход эргэлзээ үүссэнтэй холбоотойгоор шүүхээс тус зарчмыг баримтлан шийдвэрлэсэн тохиолдол нийт судалсан шийдвэрийн 81.2%-ийг эзэлж байна.

Эдгээр шүүхийн шийдвэрүүдийн нийтлэг үндэслэлийг тодруулбал:

2.2.1.1. Шүүхийн шийдвэрт эргэлзээ бүхий нөхцөл байдлыг буруу дүгнэх буюу дүгнэлтэд онцгой ач холбогдолтой нотлох баримтууд харилцан зөрүүтэй байхад аль нэгийг нь авахдаа бусдыг нь үгүйсгэсэн үндэслэлээ заах байдлаар зөрүүг арилгахын оронд шууд эргэлзээ хэмээн үзэж, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг хэрэглэжээ.

Шүүх хэргийн бодит байдлыг прокуророос шүүхэд шилжүүлсэн хавтаст хэргийн хүрээнд хэрэгт хамааралтай баримт нэг бүрийг бусад нотлох баримтуудтай харьцуулан нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар хянах үүрэгтэй. Энэ нь шүүгдэгчийн Үндсэн хуулиар баталгаажуулсан шударга шүүхээр шүүлгэх эрхийн хамгаалалт юм.

Нотлох баримтыг үнэлэх, шалгах ажиллагааг дутуу дулимаг хийх, шүүхийн шийдвэрийн үйл баримтын үндэслэл тодорхойгүй байх нь Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрхийг зөрчигдөхөд хүргэх бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 36.7 болон 36.9 дүгээр зүйлүүдэд заасан шүүхийн шийдвэр тодорхой, эргэлзээгүй, үндэслэл бүхий байх хуулийн зохицуулалтыг ноцтой зөрчсөн зөрчилд тооцогдоно.

2.2.1.2. Хэргийн талаар нотолбол зохих байдлуудыг бүрэн шалгаж тогтоогоогүй, хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй буюу нотлох баримтын хүрэлцэхүйц байдал бүрдээгүй байхад эргэлзээ гарсан гэж үзэж шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг баримталсан байна.

Өөрөөр хэлбэл, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой бүхий л нотлох баримтыг шалгасан байх урьдчилсан нөхцөл хангагдаагүй байхад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь нотолгооны стандартыг алдагдуулж **“in dubio pro reo”** зарчмыг баримтлан хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгдэгчийн гэм бурууг нотлох, үгүйсгэх аль нэг шийдвэрийг гаргахын тулд үйл баримтад үнэн зөв дүгнэлт хийх боломжийг олгох үүднээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах нотолгооны стандартыг нарийвчлан тогтоодог нь эрүүгийн эрх зүйн онол болон олон улсын түвшинд тогтсон ойлголт юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлд заасан хэргийн бодит байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой хянаж, эргэлзээгүй тогтоох зарчим нь хуулиар тогтоосон эрүүгийн хэрэгт баримтлах нотолгооны стандарт мөн. Үүний тулд хэрэгт хамааралтай, ач холбогдолтой бүхий л нотлох баримтуудыг судалж үзсэний үндсэн дээр шүүх аль нэг талд шийдвэр гаргахыг шаардана. Эдгээрийг нэг бүрчлэн судалсан боловч эргэлзээ бүхий нөхцөл байдал үүссэн бол түүнийг шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэхийг тус хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тусгасан байхад гэмт хэргийн шинж хангалттай нотлон тогтооход хүрэлцэхүйц нотлох баримтууд хавтаст хэрэгт цуглараагүйг үндэслэл бүхий эргэлзээтэй нөхцөл байдалтай адилтгах байдлаар тус зарчмын агуулга, зорилгыг алдагдуулсан байна;

2.2.1.3. Хоёр өөр субъектийн өөр өөр цаг хугацаанд, тус тусдаа үүссэн санаа зорилгоор, бие даасан салангид үйлдлүүдээр хохирогчид халдаж нэг төрлийн хохирол, хор уршигт хүргэсэн нөхцөл байдлыг зөв тайлбарлаагүйн улмаас эргэлзээ үүссэн гэж алдаатай дүгнэсэн;

2.2.1.4. Гэмт хэрэгт хоёр болон түүнээс дээш этгээд оролцсон тохиолдолд хамтран оролцох хэлбэр, төрөл, оролцогч тус бүрийн үйлдлийн шинж чанар, гэмт үр дагаварт хүрэхэд нөлөөлсөн нөлөө зэргийг оновчтой тогтоож чадаагүй;

2.2.1.5. Хэрэгт хамааралтай, ач холбогдолтой бүхий л нотлох баримтуудыг цуглуулж, шинжилсэн боловч шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж дүгнэхэд эргэлзээ үүссэн байхад шүүх тус зарчмыг баримтлаагүй зэрэг болно.

Дээр дурдсаныг дүгнэвэл, шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг тогтооход шаардлагатай бүх нотлох баримтуудыг тал бүрээс нь, бүрэн бодитой судлаагүй байх, нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн, зөрчилдсөн



баримтуудыг тус бүрд нь хооронд нь харьцуулж үнэлээгүй байх, хэргийн бодит байдлыг бүрэн тогтоогоогүй байх, нотлох баримтуудаар хөдөлбөргүй, эргэлзээгүй тогтоогоогүй байхад шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэсэн байхын зэрэгцээ хэргийг шийдвэрлэхэд нотлох баримтын хүрэлцэхүйц байдал хангагдаагүй буюу нотолгооны стандарт бүрдээгүй, тус зарчмыг хэрэглэх хуульд заасан урьдчилсан нөхцөл хангагдаагүй байхад шүүхээс нотлох баримтуудыг хэрхэн үнэлэн эргэлзээг тогтоосон нь тодорхойгүй, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг эргэлзээгүй, тодорхой бичихгүйгээр эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад үүссэн аливаа тодорхой бус байдлыг шууд эргэлзээ гэж тайлбарлах зэргээр хуулийг алдаатай хэрэглэжээ.

2.2.2. “... Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарсан ...” үндэслэлийг баримталсан нийт судалсан шийдвэрийн 18.96% буюу 11 тогтоол байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарсан үндэслэлээр хянан шийдвэрлэсэн шийдвэрүүдийн дийлэнх нь хуулийн хэм хэмжээнд эргэлзээ үүсэх тухай бус төсөөтэй гэмт хэргүүдийг хооронд нь ялган зүйлчлэх, аль эсвэл гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг тодорхойлоход үүссэн эргэлзээ бүхий нөхцөл байдалтай холбоотой байх ба зарим тохиолдолд практикт нэгэнт тогтсон ялгааг шүүгчийн оюун дүгнэлтээр тогтоох боломжтой байсаар атал тус зарчмыг баримтлан шийдвэрлэжээ.

Мөн хэм хэмжээ хоорондын зөрчилдөөн, өрсөлдөөний аль нэг нь үүссэнийг хуульд тайлбарлах, хэрэглэхэд гарсан эргэлзээ гэж үзсэн тохиолдлууд байна.

Энэхүү зарчим нь эрүүгийн материаллаг болон процессын хуулийн заалтыг тайлбарлахад хэрэглэгддэггүй. Хэргийн үйл баримтыг шүүхээс судалсны дараа хуульд байгаа хамгийн зөв оновчтой шийдлийг олж, тухайн хэргийг зүйлчлэх нь нэг талаас шүүхийн бүрэн эрх, нөгөө талаас чиг үүрэг нь юм. Харин уг зарчмын хүрээнд хуулийн агуулгыг шүүгдэгчид ашигтайгаар тайлбарлаж, хэрэглэх тухай ойлголт байх боломжгүй.

Иймд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “... **эргэлзээ гарвал ... шүүгдэгчид ... ашигтайгаар шийдвэрлэх**” зарчмыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай албан ёсны тайлбар гаргах хэрэгцээ, шаардлага үүссэн гэж үзсэн болно.

Гурав. Тайлбарын цар хүрээ

3.1.Тайлбарын цар хүрээ нь Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дараах үг хэллэг, агуулгаар хязгаарлагдана.

3.1.1.“*Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч ...*”;

3.1.2.“*... шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд ...*”;

3.1.3.“*... эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал ...*”;

3.1.4.“*... шүүгдэгчид ... ашигтайгаар шийдвэрлэнэ*”.

Дөрөв. Тайлбарын арга зүй

4.1.Тайлбарын холбогдох хэсэг тус бүрд тохирох хууль тайлбарлах аргаар, тухайлбал, хууль зүйн ойлголт, ухагдахууныг эрх зүйн онол, нийтлэг зарчимд нийцүүлэн тайлбарлах; системчлэлийн (хэм хэмжээний бүтцийн нэгдмэл, уялдаатай байдлыг хангах); хуулийн зорилго, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн тайлбарлах (teleological) аргаар тус тус тайлбарлана.

Тав. Тайлбарын дэлгэрэнгүй үндэслэл

Тайлбар гаргахтай холбогдуулан хийсэн онол болон практик, харьцуулсан судалгааны үр дүнгээр илэрсэн “*... эргэлзээ гарвал түүнийг ... шүүгдэгчид ... ашигтайгаар шийдвэрлэх*” буюу “*in dubio pro reo*” зарчмын суурь ойлголт, Эрүүгийн болон Эрүүгийн процессын эрх зүйн ач холбогдол, зорилго, нийтлэг зарчим, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг үндэслэл, зорилгыг баримтлан дараах байдлаар тайлбарлалаа:

5.1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгдэгчийн гэм бурууг эцэслэн тогтоох ажиллагаа зөвхөн нотлох баримтад үндэслэнэ. Шүүх эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхдээ хэрэгт авагдсан нотлох баримтыг бүх талаас нь шинжлэх, гэмт хэрэгт холбогдсон этгээдийн гэм бурууг тогтоохдоо мөрдөн байцаалтын шатанд цугларсан бүхий л нотлох баримтыг (*анхдагч болон дамжмал, яллах ба цагаатгах, шууд болон шууд бус*) шүүхийн аман хэлэлцүүлгээр шинжлэн, нэг бүрчлэн судалсны үндсэн дээр хэнээс ч хараат бусаар шийдвэрлэдэг.

Шүүхээс “гэм бурууг тогтоох” ажиллагааны явцад *“in dubio pro reo”* зарчим нь эрүүгийн эрх зүйн шударга ёсны зарчмыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, төр, хуулийн байгууллагын зүгээс хууль зүйн үндэслэлгүйгээр хүний эрх, эрх чөлөөнд халдах явдал гаргуулахгүй байх нөхцөл бүрдүүлэхэд чиглэдэг учраас шүүгдэгчийг гэм буруутай эсэхэд эргэлзээ үүссэн нөхцөлд түүнд ашигтайгаар шийдвэрлэх утга агуулгаар хэрэглэгддэг.

Иймд шүүх *“in dubio pro reo”* зарчмыг хэрэглэх үндэслэл нь хэргийн үйл баримт, хэрэгт цугларсан нотлох баримтыг үнэлэх явцад “эргэлзээ үүссэн” нөхцөл байдал байна.

Шүүгч нь хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгон хэргийн бүх байдлыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлэх ба нотлох баримт тухайн хэрэгт хамааралтай эсэх, ач холбогдолтой эсэх, хангалттай эсэх, үнэн зөв эсэх, эргэлзээгүй эсэх, хуульд заасан арга хэрэгслээр цугларсан эсэх зэргийг тал бүрээс нь бүрэн, бодитой шинжлэн шалгаж, үнэлснээр хэргийн болж өнгөрсөн жинхэнэ нөхцөл байдлыг бүрэн, бодитой сэргээн тогтоож, хэргийн зүйлчлэл зөв эсэх, хэрэгт авагдсан бусад баримт бичиг, хийгдсэн нотлох ажиллагаа хуульд нийцсэн эсэхэд дүгнэлт гаргана.

Шүүгчийн дотоод итгэл үнэмшилд тулгуурлах зарчим нь *“шүүхэд сонсгох”* хүний үндсэн эрхийн ойлголттой холбоотой ба хүн бүр өөрт холбогдох хэргийн талаар шүүхэд сонсгол хийлгэх эрхтэй бөгөөд энэ нь Үндсэн хуулиар хамгаалсан шударга шүүхээр шүүлгэх эрхийн нэг хэсэг болдог.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, анхан, давах, хяналтын шатны шүүх хуралдаанд нотлох баримт шинжлэн судлуулах, тайлбар гаргах, эрх тэгш мэтгэлцэх замаар шүүхэд өөрийн байр суурийг илэрхийлж сонсгох, шүүх түүнийг хүлээн авч улмаар шүүгчийн дотоод итгэл үнэмшилд хэргийн бодит байдал хэлбэржин тогтож байдаг.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 10, 13, 14, 15 зэрэг нотлох баримттай холбоотой заалтууд нь “шүүхэд сонсгох” эрхийг хуульд бэхжүүлж өгсөн байна.

Ийнхүү “шүүхэд сонсгох” ажиллагааг шүүх үр дүнтэй явуулснаар шүүгчийн дотоод итгэл үнэмшлийг бүрдүүлэх, мөн хэрэгт цугларсан нотлох баримтыг зөв үнэлэх зэрэгт туслах ач холбогдолтой.

“Шүүхэд сонгох” эрхийн хүрээнд дараах гурван асуудал хамаардаг.

Нэгдүгээрт. Шүүх нь шийдвэр гаргагч болохынхоо хувьд өөр этгээдээр дамжуулж бус харин өөрөө нотлох баримтыг шууд чөлөөтэй үнэлдэг.

Хоёрдугаарт. Эрүүгийн процессын эрх зүйд аман харилцааны зарчим үйлчилнэ. Энэ зарчмын агуулга нь шүүгч урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хуралдааны явцад шүүгдэгч, улсын яллагч, өмгөөлөгч, хохирогч болон бусад оролцогч нартай өөрөө шууд харилцахыг ойлгоно. Ингэхдээ шүүх хуралдааны явцад гаргаж байгаа шийдвэр бүрийн тухайлсан үндэслэл бүрийг аман хуралдаанаар баталгаажуулна. Харин амаар харилцаагүй, баталгаажуулсан бол шүүхийн шийдвэрт тусгахгүй.

Гуравдугаарт. Шүүх нь дотоод итгэл үнэмшлийг аман хуралдааны үед олж авах бөгөөд шүүгчийн хараат бус байдлын үндсэн дээр өөрийн чөлөөт итгэл үнэмшлээр нотлох баримтын үр дүнг үнэлнэ. Өөрөөр хэлбэл, амаар харилцаж, итгэл үнэмшлээ олж, түүн дээрээ үр дүнг бий болгоно гэсэн үг юм.

Иймд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг тогтоохын тулд хуульд заасан арга, хэрэгслээр шаардлагатай бүхий л ажиллагааг хийсний эцэст шүүхийн шийдвэрт нөлөөлж болох тодорхой эргэлзээ үүсээгүй, эсхүл уг үүссэн эргэлзээтэй гэх асуудлыг шүүх заавал няцаан үгүйсгэсэн байх ёстой бөгөөд няцаан үгүйсгэгдэхгүй бол тэрхүү эргэлзээг тухайн хүнд ашигтайгаар шийдвэрлэх буюу **“in dubio pro reo”** гэсэн эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг хэрэглэнэ.

5.2. Шүүгдэгчийн гэм буруутай, эсхүл гэм буруугүйг тогтоож байгаа шүүхийн шийдвэрт тавигдах шаардлага бол үндэслэл болгосон нотлох баримт нь шүүгдэгчийн гэм бурууг бүрэн дүүрэн нотолж, хэргийн үйл баримтыг үнэн зөвөөр тогтоох явдал юм.

Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд гарах аливаа шийдвэрт тавигдах шаардлага нь нотлогдсон үйл баримтад тулгуурлах ёстой бөгөөд нотолгооны хувьд үүссэн бүх зөрүүг арилгахгүйгээр эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэх бодит боломжгүй.

“in dubio pro reo” зарчмын үзэл баримтлал нь эрх зүйн ач холбогдолтой үйл баримтад үүссэн эргэлзээг шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх, мөн түүний гэм бурууг нотолж байгаа үйл баримтууд хөдөлбөргүй нотлогдож байхыг шаарддаг. Энэхүү эргэлзээ нь зөвхөн “үндэслэл бүхий” байна.



Үндэслэл бүхий эргэлзээ гэдэгт эрүүгийн хэрэгт цугларсан бүхий л нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитой, нягт нямбай шалгаж, эрх тэгш талуудын мэтгэлцээн, шүүхийн хэлэлцүүлгийн үр дүнгээр тогтоогдсон хэргийн үйл баримт, түүнд шууд болон шууд бус ач холбогдолтой бүхий л нотлох баримтын эх сурвалж, хүрэлцээт байдлыг хангалттай нэг бүрчлэн шалгаж, тэдгээрт дүн шинжилгээ хийсэн боловч шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтоох үйл баримтад тодорхой бус нөхцөл байдал гарсан байхыг ойлгоно.

Дүн шинжилгээ хийх явцад шүүгч өөрийн хууль, эрх зүйн ухамсар, мэргэжлийн болон шинжлэх ухааны мэдлэг, туршлагыг ашиглаж дотоод итгэл үнэмшлийг бүрдүүлж байдаг.

Үндэслэл бүхий эргэлзээ нь рациональ байдлаар буюу шүүгчийн субъектив дур зоргоос ангид тодорхой бодит нотолгоонд үндэслэгдсэн байх ёстой бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үндэслэл бүхий эргэлзээ үүссэн бол гэм буруутай нь тогтоогдоогүй хэнийг ч ял шийтгэхгүй байх гэм буруугийн зарчмын зорилготой уялдуулан шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх нөхцөл боломжийг олгодог болно.

Нотлох баримтыг шалгах, үнэлэх нь хийсвэр таамаглал, субъектив хүсэл зориг, үзэмжийн асуудал биш шүүхээс нотлох баримтыг шалгах, үнэлэх явцад үүссэн эргэлзээ бүхий нөхцөл байдлыг даван туулахын тулд рациональ сэтгэлгээ, логикийн болон шинжлэх ухааны арга зүйд тулгуурласан туршилтын хуулиуд, шинжлэх ухаан-танин мэдэхүйн дүрэм, арга зүйг ашиглах, тэдгээрт тулгуурлан дүгнэлт хийсэн байх шаардлагатай.

Рациональ байдал гэдэг нь оюун дүгнэлт хийдэг логикийн хуулиуд болон шинжээчийн дүгнэлт, шинжлэх ухааны арга зүйд тулгуурласан туршилтын хуулиудад түшиглэн шүүгч өөрөө эргэлзээгээ тайлахыг ойлгоно.

Оюун дүгнэлт нь:

- хуулийн тодорхойлолт, бичвэрийг буруу, зөрүү ойлгосон эсэх;
- мэдүүлгүүдийн (шүүгдэгч, гэрч, хохирогчийн гэх мэт) агуулгыг зөв ойлгосон эсэх;
- гэрчийн мэдүүлгийн худал, тогтворгүй байдал анзаарагдсан эсэх; гэрчийн мэдүүлгийг үгүйсгэх өөр нотлох баримт байгаа эсэх; гэрчүүдийн мэдүүлэг хоорондоо зөрүүтэй эсэх; сэтгэцийн өвчтэй, сэтгэцийн хямралтай, сэтгэцийн үйл ажиллагаа тогтворгүй гэрч эсэх болон гэрч сонссоноо ярьсан эсэх зэрэг эргэлзээ үүсгэх бусад эх үүсвэрүүдийг шалгах;
- тооцооллын алдаа гаргасан эсэх;
- яллах болон цагаатгах нотлох баримтуудын талаар хийсэн дүн шинжилгээ зөв эсэхэд дүгнэлт хийх явдал юм.

Шинжээчийн дүгнэлтийн хувьд шүүгч хүлээн зөвшөөрөгдсөн шинжээчийн дүгнэлтийн эсрэг шийдэж болохгүй; харин шинжээчийн дүгнэлтүүд хоорондоо зөрүүтэй үр дүн үзүүлбэл эргэлзээ үүсэж болох бөгөөд энэ тохиолдолд аль нь үндэслэлтэйг тогтоох шаардлага үүснэ.

Шинжээчийн дүгнэлтийг эргэлзээтэй гэж үзсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу шинжээчийн дүгнэлтийг шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа бол үндэслэлийг заавал заана. Харин хэд хэдэн дүгнэлт гарсан тохиолдолд тэдгээрийг нэг бүрчлэн хэлэлцэж алиныг нь нотлох баримтаар тооцохыг шийдвэрлэх үүрэгтэй.

Шинжээчийн дүгнэлтүүд зөрүүтэй, эргэлзээтэй байхад тухайн зөрүү, эргэлзээг арилгах арга хэмжээ авалгүйгээр аль нэг дүгнэлтэд хөтлөгдөж, хэргийн зүйлчлэлд алдаа гаргахгүй байхад анхаарах нь нэн чухал. Зөрүүтэй шинжээчийн дүгнэлт байгаа тохиолдолд аль дүгнэлтийг хууль ёсных гэж үзэхээ зөв, үндэслэлтэй шийдвэрлэх, хэрэв эргэлзээ, зөрүү байгаа бол заавал дахин дүгнэлт гаргуулан тухайн зөрүүтэй байдлыг зөв тогтоохгүйгээр хэргийн зүйлчлэлийг өөрчлөх ёсгүй.

Харин шүүгч шинжлэх ухааны арга зүйд тулгуурласан туршилтын үр дүнд нотлогдсон үйл баримтад эргэлзэхгүй. Үүнд: цусан дахь алкохолын хэмжээ; цусны бүлгийн шинжилгээгээр эцэг тогтоосон байдал; ДНХ шинжилгээний үр дүн; хурдны хэмжилтийн үр дүн; микроморфологийн шинжилгээний үр дүн; радарын зураг; замын хөдөлгөөний зайг хэмжсэн ажиллагааны үр дүн гэх мэт.

Дараах тохиолдлуудад эргэлзээ байсан хэдий ч *“in dubio pro reo”* зарчмыг хэрэглэхгүй, харин Эрүүгийн хууль, түүнд тусгагдсан суурь зарчмууд, эрүүгийн эрх зүйн онолуудыг баримтлан шударга ёс, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчимд нийцүүлж шүүх тодорхойгүй байдлыг тайлах, шийдвэр гаргах үүрэгтэй.

1.Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр, төрөл тодорхойгүй бол холбогдох хэргийг шууд хэрэгсэхгүй болгохгүй. Гэмт хэрэгт хамтран оролцох тухай ойлголт нь олон субъект нийлж гэмт хэрэг үйлдсэн үед субъект тус бүрийн оролцоог тодорхойлж, улмаар эрүүгийн хариуцлагыг ялгамжтай хүлээлгэх тухай юм. Бодит байдал дээр хуулиар хориглосон үйлдэл, үр дагаварт хүргэхэд хэд хэдэн этгээд хамтран хувь нэмэр оруулсан нь тодорхой боловч гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрийг тогтооход бэрхшээл учирч болно. Өөрөөр хэлбэл, субъектууд гэмт санаагаараа нэгдэн гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн буюу шүүгдэгч тус бүр гэмт хэргийн гүйцэтгэгч эсэх нь тодорхой биш байж болно. Энэ тохиолдолд хамтран оролцогчдын үүргийг (төрлийг) нотлох баримтаар тогтоогдсон хэмжээнд



тодорхойлж, Эрүүгийн хуульд заасан холбогдох зүйл, заалтыг баримтлан, жишээлбэл, хамжигч, хатгагч, зохион байгуулагчийн аль тохирохоор (хөнгөнөөр) нь зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

2.Хэд хэдэн этгээдийн үйлдэл нийлж нэг хохирол, хор уршигт хүргэсэн бол шүүгдэгч тус бүрд эрүүгийн хариуцлага оногдуулна. Өөрөөр хэлбэл, тусдаа үүссэн гэмт зорилго, сэдлээр нэг объектод тус тусдаа үйлдлээр халдаж нэг хор уршигт хүргэсэн бол бие даасан гэмт санаа бүрд эрүүгийн хариуцлага оногдуулна. Аливаа этгээдийг ял шийтгэх үндэс нь нийгэмд аюултай гэмт санаа агуулж, түүнийгээ үйлдлээр гүйцэтгэж, хуулиар хамгаалсан эрх ашигт халдсан явдал байдаг. Гэмт санаа, зорилгоо үйлдлээрээ хэрэгжүүлж, өөрийн тооцоолсон үр дагаварт хүрсэн гэж итгэсэн бол тухайн субъектийн оюун санаанд гэмт хэрэг нэгэнт төгссөн байдаг.

3.Гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн хангалттай тодорхой тогтоогдоогүй бол ердийн бүрэлдэхүүнээр эрүүгийн хариуцлага оногдуулна. Шүүгдэгчид холбогдох хэрэгт гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжүүд хангалттай, тодорхой тогтоогдоогүй нь ердийн бүрэлдэхүүнээр эрүүгийн хариуцлага оногдуулахад аливаа эргэлзээ үүсгэхгүй юм.

Харин дараах нөхцөл байдлуудад эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд эргэлзээ үүссэн гэж шууд дүгнэх боломжгүй.

1.Шүүх хууль зүйн дүгнэлт хийхэд ач холбогдолтой боловч нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн нотлох баримтуудад дүгнэлт хийхгүйгээр шууд эргэлзээтэй нөхцөл байдлыг тогтоох боломжгүй юм. Ийнхүү шүүх шийдвэрийнхээ үндэслэлийг тайлбарлахгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болговол шүүгдэгч, хохирогч болон хэргийн оролцогчдын шударга шүүхээр шүүлгэх эрх хөндөгдөх эрсдэлтэй. Иймээс шүүх шийдвэрийн үндэслэл болгосон нотлох баримтуудад өгсөн дүгнэлтээ логик оюун дүгнэлтийн дүрмүүд, мэргэжлийн болон шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдлэг, туршлагад үндэслэж тайлбарлах үүрэгтэй.

2.Түүнчлэн хэргийн талаар нотолбол зохих байдлуудыг бүх талаас нь бүрэн бодитой, хангалттай шалгаж тодруулаагүй нөхцөлд үүссэн аливаа тодорхойгүй байдлыг эргэлзээ гэж тооцохгүй.

Иймд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад үүссэн тодорхойгүй нөхцөл бүрийг эргэлзээ гэж үзэхгүй бөгөөд **“in dubio pro reo”** зарчмын зорилго, мөн чанарыг өргөжүүлэн хэрэглэх нь эрүүгийн процессын эрх зүйн эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, ял завшуулахгүй байх зорилтуудад харшилна.

5.3.**“in dubio pro reo”** зарчмын тухайд хуулийг тайлбарлан хэрэглэхэд үүссэн эргэлзээ гэх ойлголт хамаарахгүй. Өөрөөр хэлбэл, хууль

тайлбарлаж хэрэглэхэд үүссэн ойлгомжгүй, тодорхойгүй байдал, хуулийн хэм хэмжээ хоёрдмол утгатай тохиолдолд энэ зарчмыг хэрэглэхгүй, харин хууль тайлбарлах аргуудыг хэрэглэх замаар хуулийн хэм хэмжээний агуулгыг тодруулах нь шүүгчийн үүрэг юм.

Шүүх “хуулийг тайлбарлан хэрэглэх” гэдэг нь эргэлзээг шийдвэрлэх тухай биш харин хуулийг зөв хэрэглэх тухай агуулгыг хөнддөг тул энэ ойлголт нь үйл баримтыг нотлох баримт дээр тулгуурлан үнэлж дүгнэхэд үүссэн эргэлзээнээс ялгаатай юм.

Шүүх “хуулийг хэрэглэх” гэдэг нь тодорхой үйл баримтыг гэмт хэргийн бүрэлдэхүүнд нийцсэн эсэхийг оюун дүгнэлт хийж шалгахыг хэлэх бол, “хууль тайлбарлах” гэдэгт хууль тайлбарлах тогтсон аргуудын тусламжтайгаар хуулийн агуулгыг тодруулж, хэрэглэх аргачлалыг тодорхойлохыг ойлгоно.

Аливаа хууль нь “*lex certa*” (лат. тодорхой байх) зарчмын шаардлагыг хангахгүй бол шүүх хуулийг тайлбарлах замаар хуулийн агуулгыг тодруулан хэргийг шийдвэрлэнэ. Жишээ нь: отолтод оруулж хүнийг алах гэмт хэрэг нь ердийн байдлаар хүнийг алах гэмт хэрэгтэй адилгүй, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг гэх тайлбарыг шүүхээс хийсэн гэж үзье. Энэ тайлбар нь тухайн үед шүүгдэгчид ашигтайгаар үйлчилсэн байж болох ч энэ нь “*in dubio pro reo*” зарчмын үр дүн биш, “ердийн байдлаар” гэх гэмт хэргийн бүрэлдэхүүний нэг шинжийг тодорхойлсон нэр томьёонд хийсэн тайлбар юм.

“*in dubio pro reo*” зарчим нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болон бодит байдал дахь үйл баримтын хооронд бий болсон нотлох баримтын үнэлгээнд үүссэн эргэлзээнд хэрэглэгддэг.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал ...” гэж заасан нь хуульд үүссэн эргэлзээ бус харин нотлох баримтаар тогтоогдсон хэргийн үйл баримтыг хуульд заасан гэмт хэргийн шинжтэй харьцуулан жишиж, зүйлчлэл (субсумци) хийх үед үүссэн эргэлзээг хэлнэ.

Өөрөөр хэлбэл, үйл баримттай зүйлчлэл тохирохгүй байх үед хэргийн үйл баримтыг шүүхээс судалсны дараа хуульд байгаа хамгийн оновчтой шийдлийг олж, тухайн хэргийн зүйлчлэлийг зөв сонгож субсумци хийх асуудлыг хууль тогтоогч илэрхийлсэн байна.

Энэ тохиолдолд шүүх “*jura novit curia*” буюу “шүүх хуулийг мэднэ” гэх зарчмыг баримтална. Энэ нь хүний үйлдсэн үйлдэл гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангасан эсэхийг шүүх хууль

тайлбарлах замаар өөрөө шийдвэрлэх агуулгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, хуульд эргэлзэхгүй буюу хууль тайлбарлах замаар заавал шийднэ.

Хуулийг хэрэглэх явцад түүнийг тайлбарлах шаардлага үүсэх нь түгээмэл бөгөөд ийнхүү тайлбарлахад үүсэх үндсэн бэрхшээл нь тухайн асуудлыг зохицуулж буй хэм хэмжээ хоорондын зөрчилдөөн, өрсөлдөөнийг ялган зааглах явдал юм.

Тодруулбал, дараах тохиолдлуудын аль нэг бий болсон нь **“in dubio pro reo”** зарчмын дагуу үүссэн эргэлзээ гэж үзэх үндэслэл болохгүй ба эдгээрийг шийдэхдээ Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэж болохгүй.

- эрх зүйн нэг харилцааг Эрүүгийн хуулийн ерөнхий болон тусгай анги, эрүүгийн процесс хуулиудад хэд хэдэн хэм хэмжээгээр зохицуулсан буюу хэм хэмжээний өрсөлдөөн үүссэн;

- тодорхой эрх зүйн асуудлыг зохицуулах хэд хэдэн хэм хэмжээ үйлчилж буй бөгөөд тэдгээр нь хоорондоо зөрчилдсөн.

Дээрх тохиолдлууд буюу холбогдох хууль хоорондын өрсөлдсөн, зөрчилдсөн хэм хэмжээ болон тэдгээрийн агуулгыг тайлбарлах, хэрэглэхэд ойлголтын зөрүү үүссэн байх нь **“in dubio pro reo”** зарчмын утга, агуулга, үйлчлэлд хамаарахгүй гэж үзнэ.

Хуулийг тайлбарлах явцад үүссэн бэрхшээлийг системчилсэн тайлбарын арга, хэл зүйн тайлбар, логик, түүхчилсэн зэрэг хууль тайлбарлах үндсэн аргуудын тусламжтайгаар даван туулна. Тодруулбал:

- аливаа эрх зүйн хэм хэмжээг тухайн хэм хэмжээний тогтолцооны хүрээнд бүхэллэг байдлаар нь уялдаа холбоо, зорилгын харилцан хамааралтай авч үзэж тайлбарлах буюу системчилсэн тайлбар хийх;

- үгийн утга, өгүүлбэр зүйн бүтэц, найруулга, хэл зүйн дүрмүүдийг ашиглаж тайлбарлах;

- эрх зүйн хэм хэмжээ батлагдах цаг үеийн үзэл баримтлалтай уялдуулж тайлбарлах;

- логикийн нийтлэг хууль, дүгнэлт категориуд, оюун дүгнэлтийн тусламжтайгаар тайлбарлах зэрэг болно.

Үүнээс гадна тухайн тохиолдлыг зохицуулсан хэд хэдэн хэм хэмжээ байх бөгөөд тэдгээрийн хоорондын өрсөлдсөн, зөрчилдсөн

нөхцөл байдлыг эрх зүйн ерөнхий онолын дагуу дараах үндсэн 3 зарчмыг баримтлан даван туулна:

- **“lex superior”** буюу дээд шатны байгууллагаас баталсан хэм хэмжээ давуу хүчинтэй үйлчлэх;

- **“lex specialis”** буюу нарийвчилсан зохицуулалт бүхий хэм хэмжээг ерөнхий зохицуулалттай хэм хэмжээнээс тэргүүн ээлжид хэрэглэх;

- **“lex posterior”** буюу шинээр баталсан хэм хэмжээ нь өмнө үйлчилж байсан хэм хэмжээнээс давуу хүчинтэй үйлчлэх зэрэг болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно ...”, мөн зүйлийн 14 дэх хэсэгт “... Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно”, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй”, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заагаагүй үйлдэл, эс үйлдэхүй, хохирол, хор уршиг, гэм буруугийн шинжийг төсөөтэй хэрэглэж гэмт хэрэгт тооцохгүй”, мөн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид гэмт хэрэгт тооцох үйлдэл, эс үйлдэхүйг тусгайлан заана”, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална”, мөн хуулийн 1.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх, прокурор, мөрдөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина”, мөн хуулийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглоно” гэж тус тус зааснаас үзэхэд Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зүйл, заалт “тодорхой байх” зарчмыг бэхжүүлж, эргэлзээгүй, нэг мөр ойлгогдож хэрэглэгдэх ёстойг илэрхийлж байна.

Харин Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэм хэмжээн дэх эрх зүйн тодорхой бус ойлголтын улмаас (2-оос дээш агуулгыг илэрхийлэх) “тодорхой байх” зарчим зөрчигдсөн

тохиолдолд шүүх тухайн хуулийг хэрэглэж болохгүй ба үүний оронд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт *“Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар санал гаргах ба Улсын дээд шүүх уг саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана”* гэж заасны дагуу шийдвэрлүүлнэ.

5.4. Хэрэг хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийн гэм буруу, хэргийн үйл баримт хангалттай тодорхой, бодитой байх зарчмын дагуу сэргээн тогтооход үндэслэл бүхий эргэлзээ үүссэн бол эрүүгийн эрх зүйн энэрэнгүй ёсны зарчим, гэм буруугүйн зарчмуудад нийцүүлэн шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлж, түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгах, эсхүл хөнгөрүүлэн зүйлчлэх байдлаар ашигтайгаар шийдвэрлэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх заалтыг удирдлага болгон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөв хэрэглэх талаар **ТАЙЛБАРЛАХ нь:**

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн:

1.1. **“Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч ...”** гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан хэргийн талаар нотолбол зохих байдал, түүнд шууд болон шууд бусаар ач холбогдолтой, хамааралтай, мөн хуулийн 16.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт тус тус заасан нотлох баримтын эх сурвалж дахь баримтат мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн эсэх, хүрэлцээт байдлыг хангасан эсэхийг нэг бүрчлэн шалгаж тогтоосон байхыг хэлнэ.

1.2. **“... гэм буруутай эсэхэд ...”** гэдэгт гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр болон гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээг тогтоон тодорхойлоход үүссэн үндэслэл бүхий эргэлзээг хамааруулж үзнэ.

Шүүгдэгчийн гэм буруутайг тогтоож буй нотлох баримтын эх сурвалж нь хангалттай, хүрэлцэхүйц, эргэлзээгүй буюу үнэн бодит, хүлээн зөвшөөрөхүйц эсэхэд үүссэн эргэлзээ нь дээрх ойлголтод нэгэн адил хамаарна.



Харин шүүгдэгчийн гэм буруутайг тогтоохоос бусад нөхцөл байдлыг тодруулах, нотлох баримтыг шалгах, үнэлэхэд үүссэн эргэлзээ нь уг ойлголтод хамаарахгүй.

1.3. “... Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал ...” гэдэгт гэмт хэргийн шинж, гэм буруу ба хэргийн үйл баримтын хүрээнд үндэслэл бүхий эргэлзээ үүсэхийг ойлгоно.

Өөрөөр хэлбэл, энэ нь хуульд үүссэн эргэлзээ бус харин нотлох баримтаар тогтоогдсон хэргийн үйл баримтыг хуульд заасан гэмт хэргийн шинжтэй харьцуулан жишиж, зүйлчлэл хийх үед үүссэн эргэлзээ юм.

Гэмт хэргийн зүйлчлэл, гэм буруутай нь тогтоогдсон шүүгдэгчид оногдуулах ялын төрөл, хэмжээний талаар үүссэн эргэлзээ нь дээрх ойлголтод хамаарахгүй бөгөөд энэ тохиолдолд хэргийн бодит байдалд нийцсэн зүйлчлэлийг сонгон, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахуйц ялыг оногдуулна.

Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хооронд өрсөлдсөн, зөрчилдсөн хэм хэмжээ үүссэн байх нь эргэлзээнд хамаарахгүй.

Хэрэв шүүхийн хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

1.4. Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасны эцэст гагцхүү няцаан үгүйсгэгдэхгүй буюу үндэслэл бүхий эргэлзээ үүссэн тухайн тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчим үйлчилнэ.

“... шүүгдэгчид ... ашигтайгаар шийдвэрлэнэ” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасан шийдвэрийг гаргах, эсхүл хөнгөн ялтай болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг хэрэглэхийг ойлгоно.

2. Энэ тогтоолыг 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ШҮҮГЧ

Б.АМАРБАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

АГААРЫН ХӨЛГИЙН БҮХЭЭГТ ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ТОДОРХОЙ БУСАД ҮЙЛДЛИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН НЭМЭЛТ ПРОТОКОЛ

Энэхүү протоколд Оролцогч улсууд,

Агаарын хөлгийн, эсхүл хүмүүсийн, эсхүл агаарын хөлөг дэх өмч хөрөнгөд, эсхүл хөлгийн бүхээг дэх хэвийн журам, дэглэмд аюул учруулж болзошгүй агаарын хөлгийн бүхээг дэх хяналтгүй зан хандлагын ноцтой байдал, давтамж нэмэгдэж буйд Улсууд санаа зовниж буйгаа илэрхийлснийг тэмдэглэн;

Зарим улсын зүгээс агаарын хөлгийн бүхээгт хэвийн журам, дэглэмийг сэргээн тогтоож, хяналтгүй зан төлөвийг хязгаарлахад туслалцаа харилцан үзүүлэх эрмэлзэлтэйг хүлээн зөвшөөрч;

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд 1963 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Токио хотноо гарын үсэг зурсан Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай заалтыг батлах шаардлагатайд итгэж;

дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Энэхүү Протоколоор 1963 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Токио хотноо гарын үсэг зурсан Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулав (цаашид "Конвенц" гэнэ).

2 дугаар зүйл

Конвенцын 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг дараах байдлаар өөрчилнэ:

"1 дүгээр зүйл

3.Энэхүү Конвенцын зорилгоор:

а) агаарын хөлгийн ачилт, суулгалт дууссаны дараа хөлгийн бүх гаднах хаалга хаагдсанаас эхлэн буулгалт хийхээр аль нэг хаалгыг нээх хүртэлх нислэгийн аль ч үеийг агаарын хөлөг нислэг үйлдэж байна гэж тооцох бөгөөд зайлшгүй буулт хийх тохиолдолд эрх бүхий байгууллагаас агаарын хөлөг, хөлгийн бүхээг дэх хүмүүс болон өмч хөрөнгийн талаар хариу арга хэмжээ авах хүртэл нислэг үргэлжилнэ гэж үзнэ."



b) Тээвэрлэгч улс нь бүртгэлийн улстай адил биш бол Конвенцын 4, 5 болон 13 дугаар зүйлд хэрэглэсэн "бүртгэлийн улс" гэсэн ойлголтыг "тээвэрлэгч улс" гэж тооцно."

3 дугаар зүйл

Конвенцын 2 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчилнө:

"2 дугаар зүйл

4 дүгээр зүйлийн заалтыг хөндөхгүйгээр буюу агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүмүүс, эсхүл эд хөрөнгийн аюулгүй байдал үүнийг шаардахаас бусад тохиолдолд энэхүү конвенцын аль ч заалтыг улс төрийн шинж чанартай гэмт хэрэг, эсхүл арьс үндэс, шашин шүтлэг, иргэний харьяалал, үндэстний гарал үүсэл, улс төрийн үзэл бодол, эсхүл хүйсээр алагчлах явдалд үндэслэсэн гэмт хэргийн хувьд аливаа арга хэмжээ авахыг зөвшөөрсөн, эсхүл шаардсан хэмээн тайлбарлахгүй.

4 дүгээр зүйл

Конвенцын 3 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчилнө:

"3 дугаар зүйл

1. Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон аливаа бусад үйлдлийн хувьд тухайн агаарын хөлгийг бүртгэсэн улс хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх эрхтэй.

1 bis. Дараах улс агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон үйлдэлд хэргийн харьяаллаа мөн хэрэгжүүлэх эрхтэй:

a) агаарын хөлгийн бүхээгт гэмт хэрэг үйлдсэн, эсхүл тийм үйлдэл гарсан, хөлгийн бүхээгт сэжигтэн этгээд байхад агаарын хөлөг тухайн улсын нутаг дэвсгэрт буух тохиолдолд тийнхүү буулгасан улс болон;

b) агаарын хөлгийн бүхээгт гэмт хэрэг үйлдэхэд, эсхүл тийм үйлдэл гарахад бизнесийн үндсэн үйл ажиллагаа явуулдаг газартай, эсхүл тийм үйл ажиллагаа явуулах газаргүй, байнга оршин суудаг түрээслэгчид түрээсэлсэн агаарын хөлөг байгаа тохиолдолд тээвэрлэгч улс.

2. Хэлэлцэн тохирогч улс бүр түүнд бүртгэлтэй агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэргийн хувьд тухайн бүртгэгч улсын хувьд өөрийн хэргийн харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох тийм арга хэмжээг авна.

2 bis. Хэлэлцэн тохирогч улс бүр дараах тохиолдолд агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэргийн тухайд өөрийн хэргийн харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох тийм арга хэмжээг мөн авна:

а) агаарын хөлгийг буулгасан улсын хувьд:

i) агаарын хөлгийн бүхээгт нь гэмт хэрэг үйлдсэн агаарын хөлгийн хувьд тухайн нутаг дэвсгэрээс хөөрөх сүүлчийн цэг, буухаар төлөвлөсөн дараагийн цэг, эсхүл хөлгийн бүхээгт сэжигтэн этгээд байхад агаарын хөлөг тухайн нутаг дэвсгэрт нэн даруй буусан тохиолдолд;

ii) агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүс, эсхүл эд хөрөнгийн аюулгүй байдал, түүний бүхээг дэх сахилга бат болон дэг журамд эрсдэл учруулсан;

б) агаарын хөлгийн бүхээгт гэмт хэрэг үйлдэхэд, эсхүл үйлдэл гарахад бизнесийн үндсэн үйл ажиллагаа явуулдаг газартай, эсхүл тийм үйл ажиллагаа явуулах газаргүй, байнга оршин суудаг түрээслэгчид түрээсэлсэн агаарын хөлөг байгаа тохиолдолд тээвэрлэгч улс.

2 ter. Агаарын хөлгийг буулгасан улс өөрийн хэргийн харьяаллаа хэрэгжүүлэхдээ гэмт хэрэг нь тээвэрлэгч улсын хувьд гэмт хэрэг мөн эсэхийг харгалзан үзнэ.

3. Энэхүү конвенц нь үндэсний хуулийн дагуу хэрэгжүүлсэн аливаа эрүүгийн хэргийн харьяалалд хамаарахгүй.

5 дугаар зүйл

Конвенцод дараах “3 bis дугаар зүйл” гэсэн нэмэлт оруулна:

“3 bis дугаар зүйл

Хэрэв 3 дугаар зүйлийн дагуу хэргийн харьяаллаа хэрэгжүүлж буй Хэлэлцэн тохирогч улс тийм адил гэмт хэрэг, эсхүл үйлдэлтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч нэг, эсхүл бусад олон улсаас мөрдөн байцаалт, мөрдөн мөшгөлт, эсхүл шүүхийн ажиллагааг явуулж буйг мэдсэн, эсхүл бусад байдлаар судалсан бол Хэлэлцэн тохирогч тухайн улс өөрсдийн үйл ажиллагааг уялдуулах зорилгоор Хэлэлцэн тохирогч бусад улсуудтай зохих ёсоор зөвлөлдөнө. Энэ зүйлд дурдсан үүрэг 13 дугаар зүйлийн дагуу хүлээх Хэлэлцэн тохирогч улсын үүргийг хөндөхгүй.

6 дугаар зүйл

Конвенцын 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасна.

7 дугаар зүйл

Конвенцын 6 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчилнө:

"6 дугаар зүйл

1. Агаарын хөлгийн дарга 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэрэг, эсхүл үйлдлийг агаарын хөлгийн бүхээгт тухайн этгээд үйлдсэн, үйлдэхээр завдаж байна гэж үзэх боломжит үндэслэл байвал түүнийг дараах зорилгоор хязгаарлах хүртэл боломжит арга хэмжээ авч болно:

а) агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүс, эсхүл эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалах;

б) агаарын хөлгийн бүхээгт сахилга бат, дэг журмыг сахиулах;

с) тухайн этгээдийг эрх бүхий байгууллагуудад хүргэх, эсхүл энэ Бүлгийн заалтуудын дагуу агаарын хөлгөөс буулгах бололцоо бүрдүүлэх.

2. Агаарын хөлгийн дарга эрх чөлөөг нь хязгаарлавал зохих аливаа этгээдийн эрх чөлөөг хязгаарлахад багийн бусад гишүүдээс туслахыг шаардах, эсхүл тэдэнд зөвшөөрч болох бөгөөд хяналт тавих эрхтэй нислэгийн аюулгүй байдлын ажилтан, эсхүл зорчигчоос аливаа этгээдэд хяналт тавихыг шаардахгүйгээр хүсэж буюу зөвшөөрч болно. Багийн аливаа гишүүн, эсхүл зорчигч нь агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүс, эсхүл эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалахад яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэх боломжит үндэслэл байвал тийм зөвшөөрөлгүйгээр урьдчилан сэргийлэх боломжит арга хэмжээ мөн авч болно.

3. Хэлэлцэн тохирогч холбогдох улс хоорондын хоёр талт, эсхүл олон талт гэрээ, хэлэлцээрийн дагуу үүрэг гүйцэтгэж буй нислэгийн аюулгүй байдлын ажилтан нь хууль бус үйл ажиллагаанаас, эсхүл ноцтой гэмт хэрэг үйлдэхээс агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүс, эсхүл эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалахад яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэх боломжит үндэслэл байвал тийм зөвшөөрөлгүйгээр урьдчилан сэргийлэх боломжит арга хэмжээг хэрэв гэрээ, хэлэлцээрээр зөвшөөрвөл авч болно.

4. Энэхүү конвенцын аль ч заалт Хэлэлцэн тохирогч улсын хувьд нислэгийн аюулгүй байдлын ажилтны талаар хөтөлбөр бий болгох, эсхүл тухайн улсын нутаг дэвсгэрт гадаадын нислэгийн аюулгүй байдлын ажилтан үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх хоёр талт, эсхүл олон талт гэрээ, хэлэлцээр байгуулах үүргийг үүсгэхгүй."



8 дугаар зүйл

Конвенцын 9 дүгээр зүйлийг дараах байдлаар өөрчилнө:

"9 дүгээр зүйл

1. Агаарын хөлгийн даргын үзэж байгаагаар агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн үйлдэл нь ноцтой гэмт хэрэг гэж үзэх боломжит үндэслэл түүнд байвал ямар ч этгээдийг нутаг дэвсгэр дээр нь буусан аливаа Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад тэрбээр хүлээлгэн өгч болно.

2. Агаарын хөлгийн дарга Хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрт буухаас өмнө дээрх заалтад дурдсаны дагуу бүхээгтээ байгаа этгээдийг шилжүүлэх гэж буй тухайгаа улсын эрх бүхий байгууллагад тухайн этгээдийг хүлээлгэн өгөх зорилгоор болон үндэслэлийн талаар аль болох богино хугацаанд боломжийн хэрээр мэдэгдэнэ.

3. Агаарын хөлгийн дарга сэжигтэн этгээдийг энэ зүйлийн заалтуудын дагуу хүлээлгэн өгөх эрх бүхий байгууллагад хууль ёсоор олж авсан нотлох баримт, мэдээллийг өгнө.

9 дүгээр зүйл

Конвенцын 10 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчилнө:

"10 дугаар зүйл

Энэхүү конвенцын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухайд агаарын хөлгийн дарга, багийн бусад аль ч гишүүн, зорчигч, нислэгийн аюулгүй байдлын ажилтан, агаарын хөлгийн эзэмшигч, эсхүл ашиглагч, тухайн нислэгийг нэрийнх нь өмнөөс үйлдэж байгаа этгээдийн хэн нь ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед тухайн этгээдийн хувьд хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөө хариуцлага хүлээхгүй.

10 дугаар зүйл

Конвенцод дараах "15 bis дугаар зүйл" гэсэн нэмэлт оруулна:

"15 bis дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч улс бүр 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан дараах гэмт хэрэг, эсхүл үйлдлийг агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн аливаа этгээдэд эрүүгийн, захиргааны, эсхүл аливаа бусад хэлбэрийн хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай байж болзошгүй тийм арга хэмжээ авахыг дэмжинэ. Тухайлбал:

а) багийн гишүүний эсрэг бие махбодын хүчирхийлэл үйлдэх, эсхүл ийм хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх;

б) агаарын хөлгийн аюулгүй байдал, түүнд байгаа хүмүүс, эсхүл эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор агаарын хөлгийн даргын өгсөн, эсхүл түүний өмнөөс өгсөн хууль ёсны зааврыг дагаж мөрдөхөөс татгалзах.

2. Энэхүү конвенцын аль ч заалт агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн хууль бус болон сүйтгэх үйлдлийг шийтгэх зорилгоор зохих арга хэмжээг Хэлэлцэн тохирогч улс бүр өөрийн үндэсний хууль тогтоомжид тусгах, эсхүл хадгалах эрхэд нөлөөлөхгүй.

11 дүгээр зүйл

Конвенцын 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дараах байдлаар өөрчилнэ:

"16 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч улс хооронд шилжүүлэн өгөх зорилгоор агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэргүүдийг зөвхөн үйлдэгдсэн газарт төдийгүй, мөн 3 дугаар зүйлийн 2 болон 2 bis дугаар зүйлийн дагуу Хэлэлцэн тохирогч улсуудаас хэргийн харьяаллаа тогтоохыг шаардсан тэдгээрийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэж үзнэ.

12 дугаар зүйл

Конвенцын 17 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчилнэ:

"17 дугаар зүйл

1. Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн аливаа гэмт хэрэгтэй холбогдуулан мөрдөн байцаалт явуулах, баривчлах арга хэмжээ авах, эсхүл хэргийн харьяаллаа хэрэгжүүлэхдээ Хэлэлцэн тохирогч улсууд агаарын навигацийн аюулгүй байдал болон бусад эрх ашгийг харгалзан агаарын хөлөг, зорчигчид, баг, эсхүл ачаа тээшийг шаардлагагүйгээр саатуулахгүй байхад анхаарна.

2. Хэлэлцэн тохирогч улс бүр энэхүү конвенцын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, эсхүл зөвшөөрөгдсөн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ олон

улсын эрх зүйн дагуу тухайн улсын хүлээсэн үүрэг, хариуцлагад нийцүүлэн ажиллана. Үүнтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч улс бүр зохих журам, шударга нөхцөлийн зарчмыг баримтална.

13 дугаар зүйл

Конвенцод дараах “18 bis дугаар зүйл” гэсэн нэмэлт оруулна:

“18 bis дугаар зүйл

Энэхүү конвенцын аль ч заалт 8, эсхүл 9 дүгээр зүйлийн дагуу агаарын хөлгөөс буулгасан, эсхүл албадан хүргэсэн этгээдээс учруулсан хохирлыг үндэсний хуулийн дагуу нөхөн төлүүлэх аливаа эрхэд саад болохгүй.

14 дүгээр зүйл

Энэхүү протоколд хавсаргасан араб, хятад, орос хэл дээрх конвенцын бичвэр нь англи, франц болон испани хэл дээрх конвенцын бичвэрийн хамт эдгээр зургаан хэл дээрх бичвэрээс бүрдэж, адил хүчинтэй байна.

15 дугаар зүйл

Энэхүү протоколыг Хэлэлцэн тохирогч улсуудын хооронд конвенц болон энэхүү протоколыг хамтад нь нэг баримт бичиг хэмээн уншиж, тайлбарлах бөгөөд 2014 оны Монреалын Протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Токиогийн Конвенц гэж үзнэ.

16 дугаар зүйл

Энэхүү Протокол нь 2014 оны 3 дугаар сарын 26-наас 4 дүгээр сарын 4-ний өдөр хүртэл Монреал хотноо болсон Нисэхийн аюулгүй байдлын асуудлаарх Дипломат бага хуралд Оролцогч улсууд 2014 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр гарын үсэг зурахад нээлттэй. 2014 оны 4 дүгээр сарын 4-ний өдрөөс хойш 18 дугаар зүйлийн дагуу протокол хүчин төгөлдөр болох хүртэл Монреал хотноо Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Төв байранд бүх улсууд гарын үсэг зурахад нээлттэй.

17 дугаар зүйл

1.Энэхүү протоколыг соёрхон батална, хүлээн зөвшөөрнө, эсхүл батална. Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай батламж жуух бичгээ Эх хадгалагчаар томилогдсон Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.



2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу энэхүү Протоколыг соёрхон батлаагүй, хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл батлаагүй аливаа улс түүнд хэдийд ч нэгдэн орж болно. Нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг Эх хадгалагчид хадгалуулна.

3.Протоколын Хэлэлцэн тохирогч улс биш аливаа улс энэхүү Протоколыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах нь 2014 оны Монреалын Протоколоор нэмэлт оруулсан Токиогийн конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталснаар хүчин төгөлдөр болно.

18 дугаар зүйл

1.Энэхүү Протокол нь түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай хорин хоёр дахь батламж жуух бичгийг Эх хадгалагчид хадгалуулсан өдрөөс хойш хоёр дахь сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.

2.Энэхүү Протоколыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай хорин хоёр дахь батламж жуух бичиг хадгалуулснаас хойш энэхүү Протоколыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох улс бүрийн хувьд тийнхүү соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай өөрийн улсын батламж жуух бичгээ хадгалуулсан өдрөөс хойш хоёр дахь сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.

3.Энэхүү Протоколыг хүчин төгөлдөр болсон даруйд Эх хадгалагчаас Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлнэ.

19 дүгээр зүйл

1.Оролцогч улс бүр Эх хадгалагчид бичгээр мэдэгдэх замаар энэхүү Протоколоос гарч болно.

2.Протоколоос гарах нь Эх хадгалагч мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

20 дугаар зүйл

Эх хадгалагч энэхүү Протоколд гарын үсэг зурсан өдөр, эсхүл соёрхон баталсан, баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэгдэн орсон тухай батламж жуух бичиг хадгалуулсан өдөр, энэхүү Протокол хүчин төгөлдөр болох өдөр болон холбогдох бусад мэдээллийг энэхүү Протоколын Хэлэлцэн тохирогч улсууд болон гарын үсэг зурсан бүх улсуудад нэн даруй мэдэгдэнэ.



Үүнийг батлан гэрчилж дор гарын үсэг зурсан, зохих ёсоор эрх авсан төлөөлөгчид энэхүү Протоколд гарын үсэг зурав.

Хоёр мянга арван дөрвөн оны дөрөвдүгээр сарын дөрөвний өдөр Монреал хотноо англи, араб, хятад, франц, орос болон испани хэл дээр үйлдсэн бөгөөд бүх эх бичвэрүүд адил хүчинтэй ба Бага хурлын даргын бүрэн эрхийн хүрээнд Бага хурлын нарийн бичгийн дарга нарын газар энд дурдсан ер хоногийн дотор бичвэрүүд бие биедээ нийцэж буй эсэхийг нотолж, адил хүчинтэйг тогтооно. Энэхүү Протокол Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хадгалагдах бөгөөд Эх хадгалагчаас протоколын баталгаажуулсан хувиудыг энэхүү Протоколын Хэлэлцэн тохирогч бүх улсуудад хүргүүлнэ.

---oOo---

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4.5

Индекс: 200003